

Алтан хадны бичээс*
(Урьдчилсан судалгаа)

Ц. Баттулга
(МУИС)

Говь-Алтай аймгийн Бигэр сумаас баруун хойш 15 орчим км-т "Алтан хад" хэмээх нэгэн өвөлжөө бууц буй ажээ. Тэрхүү өвөлжөөний хаданд хадыг холцруулан цохисон хоёр мөр руни бичиг болон төвд, монголоор бичсэн маанийн үсэг нилээд олон буй ажээ. Эл бичээсийг бидний шавь Н. Батзаяа анх олж илрүүлэн гар хуулбар хийж ирсэн билээ¹. Оюутан Н. Батзаяагийн гар хуулбарын үсэг тэмдэгтүүд тодорхой байсан хэдий ч нүдээр үзээгүйд уншиж судлахын түдэн зөвхөн мэдээлсэн¹ юм.

Хоёр хэсгээс бүтэх эл бичээсийг хадны өнгөн хэсгийг холцруулан, зөвхөн ором мөр үлдээх тэдүйхнээр цохиж бичсэн тул дардас авах боломжгүй ажээ. Мөн гэрэл зурагт төдий л сайн буухгүй байсан билээ. Хоёр хэсэг бичээсийг өвөлжөөний хадны цээжин хэсгийн өмнө зүг харсан толигор хаднаа зэрэгцүүлэн сийлжээ. Хоёрдугаар бичээсийг цохисон хад хоёр талаасаа хагарч унажээ. Тиймээс бичээсийн зөвхөн дунд талын хэсэг үлдсэн байна.

Нэгдүгээр бичээс:

Бичээсийн эх;

ᠶᠢᠨᠨᠠ ᠶᠢᠨᠨᠠ ᠶᠢᠨᠨᠠ.1
ᠶᠢᠨᠨᠠ.2

Үсгийн галиг;

1. l b t g n ᠑ T W D N i
2. Y W R T i

Үгийн галиг;

1. il bitignij tudunī
2. yorī

Орчуулга;

Улсын бичгийн tudun ину зорчив

Хоёрдугаар бичээс:

Бичээсийн эх;

ᠶᠢᠨᠨᠠ ᠶᠢᠨᠨᠠ.1
ᠶᠢᠨᠨᠠ.2

Үсгийн галиг;

1. č ūk Q W T
2. ᠑ G B Y ᠑

Үгийн галиг;

1. ččūk qut
2. ᠑ᠶᠢ 'baу᠑

Орчуулга;

1. ...элзий /хутаг/
2. ...баян

* ARC төслийн хүрээнд эл бичээсийг судалсан юм.

* МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг судлалын 3-р ангийн оюутан Намсрайн Батзаяа, 2001 оны 10-р сар.

¹ Ц. Баттулга, *Бигэрийн бичигт хадны бичээс*, -Монголын руни бичгийн бага дурсгалууд, тэргүүн дэвтэр, Corpus Scriptorum, Tom.I, Centre for Turkic Studies, School of Mongolian language and Culture, National University of Mongolia, Улаанбаатар, 2005, 107 дугаар тал.

Тайлбар

ᠶᠡᠨᠪᠢᠴᠢᠭᠢᠨ il bitignij - Улсын бичгийн тудун буюу түшмэл хэмээн дурдагдаж байгаагаас үзвэл Түрэгийн үед “бичиг хэрэг эрхэлсэн түшмэл” лавтай байжээ хэмээн үзэж болох юм. Сяньбигийн үед мөн “Бичээч, бичгийн түшмэл” байсан тухай лавтай мэдээ буй билээ.

ᠲᠦᠳᠦᠨ tudun - Монголчуудын хэрэглэсээр ирсэн “түшмэл” цолтой адил, төрийн албан тушаалтан, түшмэл нарт олгож асан энэ цолын утгыг тухайлан тайлбарласан нь үгүй бололтой.

Монголын руни бичгийн сонгодог дурсгалуудаас Билгэ хааны гэрэлт хөшөөний бичээсийн зүүн талын 40 дүгээр мөрд “biriyе qarluq bodun tара süle tip *tudun* yamtarigү it(t)im bardī- өмнөдөд Карлук түмэн рүү цэрэглэ хэмээн *Тудун* Ямтарыг илгээв, очив (хүрөв)” хэмээн гарах ба Ямтар тудун гэсэнгүй, нэрийн өмнө цолыг дурдсан ажээ. Мөн Булган аймгийн Могод сумын нутаг дахь Хөл Асгатын дурсгалд “täkäš köl *tudun*” гэж тохиолдоно².

“Монголын нууц товчоон”-д “qabici-ba’atur-un kö’ün menen-*tudun* büle’e menen-*tudun*-nu kö’ün qaci-külük qacin qaci’u qacula qaci’un qaraldai nacin-ba’atur dolo’an büle’e”³ хэмээн Чингис хааны угсаа гарлыг дурдахад нэг удаа тохиолдож байна. Үүнээс үзвэл XIII зуунаас хойш энэ цол хэргэмийг монголчууд хэрэглэсэнгүй бололтой.

ᠪᠯ ᠲᠦᠳᠦᠨ öcük - Уг бичээсийн эхний мөрийн хувьд нэг үгийн төгсгөлийн хоёр үсэг тэмдэгт байна гэж үзэх, бас бие даасан нэг үг хэмээн тааварлах нь тун эргэлзээтэй юм. Хэрвээ нэг үг байна гэвэл “öcük” гэж унших боломж буй.

Öcük гэх үгийг толь бичигт “tärim öcük bizkä -моё небо (божество?) служит нам очагом”⁴ гэсэн жишээ дурдан тэмдэглэжээ. Гэхдээ толь бичигт асуултын тэмдэг тавьж оруулснаас үзвэл бас ч тийм бат нут баримт биш бололтой юм.

ᠪᠯ ᠲᠦᠳᠦᠨ acük (ecük ~icük) - Хүний нэр байж болно.

ᠪᠯ ᠲᠦᠳᠦᠨ cük - нэг үгийн төгсгөлийн хоёр үсэг байх магадлалтай.

ᠲᠦᠳᠦᠨ qut - өлзий, хутаг гэх энэ үг маш тодорхой байна. Эл үгийн дараагийн үсэг, үг байхгүй учир зөвхөн “өлзий, хутаг” гэсэн үг хэмээн үзэж болохгүй. Магадгүй qutluу гэх үгийн эхний “qut” язгуур үлдсэн байж ч болох талтай. Үүнээс ургуулан монголын руни бичгийн дурсгалуудад олонтоо тохиолдох “ᠲᠦᠳᠦᠨ qutluу bolzun, ᠲᠦᠳᠦᠨ qutluу boluᠭ” гэсэн үг өгүүлбэр байна хэмээн сэргээн уншиж болох юм.

Учир нь нэгдүгээр бичээст “Улсын бичгийн Тудун /түшмэл/ явж өнгөрсөн” тухай тэмдэглэснээс үзэхэд ерөөлийн үг байх бүрэн үндэстэй. Ер түрэг, уйгурын үед аян замын болон алс ирээдүйн хутаг ерөөл гуйж бичээс сийлдэг байсныг Тайхир чулуу⁵, Арханангийн бичээс⁶ бэлхэнээ нутална.

² W. Radloff, *Die Alttürkischen inschriften der Mongolei*, St.Peterburg, 1894 (1987), pp.260-268; H. N. Orkun, *Eski Türk yazitları II*, İstanbul, 1938, (1.Baskı: 1936, 1938, 1940, 1941; 2.Baskı: Ankara, 1987; 3. Baskı: Ankara, 1987) s.107-123; С. Е. Малов, *Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии*, Москва-Ленинград, 1959, стр. 46-54; О. Намнандорж, *Арван өдрийн шинжилгээний аялал*, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №5, Улаанбаатар, 1966, 39 дүгээр тал; Rintchen, *Les dessigns pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie*, - Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI. fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.34-36; Н. Сэр-Оджав, *Их Асгатын хөшөөт булш*, - Шинжлэх Ухааны Академийн мэдээ, №1, Улаанбаатар, 1963, 91-95 дугаар тал; Н. Сэр-Оджав, *Эртний түрэгүүд (VI-VIII зуун)*, Улаанбаатар, 1970, 43-46 дугаар тал; Н. Сэр-Оджав, *Монголын эртний түүх* (Археологийн найруулал), Улаанбаатар, 1977, 141 дүгээр тал; Л. Болд, *Хөл асгатын түрэг бичээс*, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 135-137 дугаар тал; Л.Б олд, *Хөл Асгатын орхон бичээсийг уншсан тэмдэглэл*, -Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2000, 66-85 дугаар тал.

³ Igor de Rachewiltz, *Index to the Secret History of the Mongols*, -Indiana University Publications Uralic and Altaic Series, Volume 121, Bloomington, 1972, pp.20.

⁴ *Древнетюркский словарь*, Ленинград, 1969, стр. 376.

⁵ W. Radloff, *Die alttürkischen inschriften der Mongolei*, St.Peterburg, 1894 (1987), pp. 260-268; H. N. Orkun, *Eski Türk yazitları II*, İstanbul, 1938 (Eski Türk yazitları, 1987), s.109-117 (299-309); С. Е. Малов, *Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии*, Москва-Ленинград, 1959, стр. 46-54; Д. Д. Васильев, *Графические особенности памятников Хойто-Тамира*, -Вопросы восточного литературоведения и текстологии, Москва, 1975; Rintchen, *Les dessigns pictographiques et les inscriptions sur les rochers et sur les steles en Mongolie*, -Corpus Scriptorum Mongolorum, Tom.XVI. fasc.1, Улаанбаатар (Oulanbator), 1968, pp.34-36; Х. Пэрлээ, *Тайхир чулуу*, -Studia Archaeologica, Tom.I, fasc.IV, Улаанбаатар, 1960, 26 тал; Л. Болд, *Тайхар чулууны монгол*

ᠬᠢ үг - үгийн төгсгөлийн хоёр үсэг бололтой.

ᠶᠳᠰ байр - баян, баян чинээлэг гэсэн утгатай. Мөн хүний нэр байж болно. Хэрвээ уг үгийг ᠶ ᠳᠰ байр гэж салган уншвал "их, олон ан" гэсэн үг болох. Мөн ᠶᠳᠰ ᠬᠢ үг байр - Аниг Баян гэсэн хүний нэр байх гэсэн хувилбарыг ч гаргаж бас болно.

Эцэст нь тэмдэглэхэд хоёрдугаар бичээсийн хоёр дахь мөрийн хувьд ᠶᠳᠰ ᠬᠢ гэсэн таван үсэг тэмдэгт тодорхой байгаагаас ᠳᠰ байр гэж унших боломжтой мэт байна.

ABSTRACT

There is an ancient runic inscription at the winter cāmp named Altan Khad which is located in the northwest 15 km far from Biger soum in Gobi-Altai province. There are 2 rows of superficial runic scripts as well as very many tantra scripts that were written by Mongolian and Tibetan.

The inscription consists of 2 parts and it was carved on the smooth large rock which is on the top of the winter camp.

1st part of the inscription


Origin of the inscription		ᠶᠳᠰᠠ ᠬᠢᠶᠢᠨ .1 ᠶᠳᠰ .2
Transliteration	1. l b t g n ᠭ T W D N i 2. Y W R T i	
Transcription	1. il bitigniᠭ tudunī 2. yortī	
Translation:	The official who refers the written documents of the state visited.	

2nd part of the inscription


Origin of the inscription		ᠶᠳᠰᠠ .1 ᠶᠳᠰ .2
Transliteration	1. ᠿ ük Q W T 2. ᠭ G B Y ᠭ	
Transcription	1. öcük qut 2. ᠭᠢᠶᠢ байр	
Translation:	1. ...goodness 2. ...rich	

бичээс, -БНМАУ-ын нутаг дахь хадны бичээс, Улаанбаатар, 1990, 90-92 дугаар тал; Sertkaya O. F, Harcavbay S, *Hoşto Tamır* (Moğolistan) *dan yeni yazıtlar (ön neşir)*, -Türk Dili Araştırmaları Yıllığı, Belleten 2000, Ankara, 2001, s.313-346; *Бичээс судлалын тайлан*, -МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Түрэг судлалын тэнхим, гар бичмэлийн сан хөмрөг, 2004; *Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал* (сэдэвчилсэн лавлах), Улаанбаатар, 1999, 222 дугаар тал.

⁶Ц. Баттулга, *Бигэрийн бичигт хадны бичээс*, -Монголын руни бичгийн бага дурсгалууд, тэргүүн дэвтэр, Corpus Scriptorum, Tom.1, Centre for Turkic Studies, School of Mongolian language and Culture, National University of Mongolia, Улаанбаатар, 115-121дүгээр тал.



Алтан хад



Алтан хадны рүни бичээс